

ХОРДЛОГОТ ПОЛИНЕЙРОПАТИ ЭМНЭЛЗҮЙН ТОХИОЛДОЛ

Г.Цэндмаа¹, Н.Уянга¹, Г.Даваа²

¹АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС

²АШУУИС

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Б.Мэндхүү

Манай орны нөхцөлд Хордлогот полинейропати өвчний ховор байдаг бөгөөд УГТЭ-ийн Мэдрэлийн тасагт эмчлэгдсэн эмнэлзүйн тохиолдлыг танилцуулья. Эмнэлзүйн тохиолдол: 2021 оны 10 сарын 15 нд 50 настай эрэгтэй эмнэлэгт ирж үзүүлсэн. Ирэх үедээ өвчтөн ухаантай, арьс цэвэр, чийглэг, амьсгал минутанд 18, зүрх минутанд 76, артерийн даралт баруун талд 160/80, зүүн талд 150/90, биеийн дулаан 36.6с. Уушиг 2 талд цулцангийн амьсгалтай, Зүрхний авиа бүдэг, хэм жигд, хэвлий зөөлөн, эмзэглэлгүй, хавангүй.

Ирэх үеийн зовиур: Артерийн даралт ихсэнэ, 4 мөчний булчин чинэрч бадайрна, янгинаж өвдөнө, хэвлийд өвдөлттэй, дамжиж өвдөнө, уруул хавдана, 2 хөл сул, мэдээ муу, цээжний зүүн тал мэдээ муу. Мэдрэлийн статуст: Шөрмөсний рефлекс зүүн хөлд өндөрсөн, мэдрэхүй зүүнд Т5 дамжих, баруун талд Т3-L2 хооронд сегментийн хэв шинжээр алдагдсан. Гүний мэдрэхүй зүүн хөлд Т5 доош дамжих хэв шинжээр, зүүн Т3-L2 түвшинд сегментийн хэв шинжээр алдагдсан.



Зураг 1. СРТ-ийн шинжилгээнд нугасанд өөрчлөлт илрээгүй.

Шинжилгээнд: Цусны ерөнхий шинжилгээнд: RBC-5.0, WBC-8.1, PLT-350*10⁹/L, Hct-42%, Hb-135 г/л

Цусны биохимийн шинжилгээнд: ALAT-71.2 U/L, ASAT-126.2 U/L, Bilirubin 15.4 umol/l, creatinin 225 mol/l, glucose 6.0 umol/l, Na-152.2 mmol/l

Цээжний рентген зураг: Уушгинд голомтот болон эмгэг өөрчлөлт үгүй.

Ялган оношлогоо: 1. Полиневропати
2. Мэдрэл булчингийн өвчин
3. Нугасны хавдар

Эмчилгээ

Гормон, зүрх судасны үйл ажиллагаа сайжруулах, витамин, өвчин намдаах, антибиотик, артерийн даралт бууруулах эмчилгээ хийсэн.

Онолын мэдээлэл

Хордлогот полинейропати нь нугасны цагаан болон бор бодисыг хамарсан үрэвсэлт өвчин юм. Өвчний шалтгаан шинж тэмдгээс хамаарч, хэдэн цагаас хэд хоног хүртэл шинж тэмдэг илрэх хугацаа нь янз бүр байдаг. Бактер, вирус, тэмбүүгийн халдвар, сүрьеэ нь миелитийн шалтгаан болж болдог. Өвчтөнд голдуу 2 хөл саажих шинж тэмдэг илэрдэг бөгөөд аарцгийн эрхтний үйл ажиллагаа алдагдах шинж тэмдгээр илэрдэг. Эмчилгээнд стероид, плазмаферез, дархлаа дарангуйлах эмчилгээ хийдэг.

Дүгнэлт: Энэ танилцуулж байгаа тохиолдол болон онолын мэдээллээс үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Манай оронд тохиолдож байгаа Хордлогот полинейропати өвчин ховор бөгөөд эмч нарын дунд энэ өвчний талаар мэдээлэл бага байна.
2. Хордлогот полинейропати өвчний талаар сургалтыг эмч нарын дунд хийх
3. Хордлогот полинейропати өвчний талаар анхан шатны мэдлэгийг хүн амын дунд олгох

Ном зүй

1. Kornafel T. Physical and Occupational Therapy for a Teenager with Acute Flaccid Myelitis: A Case Report. *Phys Occup Ther Pediatr*. 2017.17:1-11. doi: 10.1080/01942638.2016.
2. Mukul P Agarwal. Concurrent reactive arthritis and myelitis – a case report. 2009 Jun 2. doi: 10.1186/1755-7682-2-17
3. Carnero Contentti E. Etiologic spectrum and functional outcome of the acute inflammatory myelitis. *Acta Neurol Belg*. 2017. Jan-10. doi: 10.1007/s13760-016-0742-y.

Abstract

In Mongolia, recently reported annual incidence of Toxic Polyneuropathy and reported reported 1 case of Toxic Polyneuropathy incident, deceased one of them Mongolian Central Hospital N3. Recent one case was diagnosed by Neurology Doctor, and overall mortality associated with late diagnosis and treatment. 50 year health man arrived. In physical examination, vital sign: RR 18/min, Pulse rate 76/min, Arterial pressure 160/80 mm Hg, SaO₂ 96%, Core T 36.6C.